

ТӨСВИЙН ЕРӨНИЙЛӨН ЗАХИРАГЧ / САЙД/ ЭРХЛЭХ АСУУДЛЫГ ХҮРЭЭНД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Чойбалсан

Аймгийн Засаг дарга салбарын эрхлэх асуудлын хүрээнд 2010 онд Монгол улсын 13 сайдтай бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжилтийн гэрээг байгуулжээ. Дээрх 13 сайдын гэрээний биелэлтийн хэрэгжилт **93.5** хувьтай гарсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн гэрээний хэрэгжилтийг салбар бүрээр товчоолон 2010 оны жилийн эцсийн байдлаар танилцуулбал:

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

Хүүхдийн хөгжил хамгааллын талаар: Аймгийн Засаг даргаас нийт 4 бүтээгдэхүүнийг **95 хувьтай** нийлүүлсэн байна. Нийлүүлсэн бүтээгдэхүүний явцаас харахад:

Аймаг, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийг хүүхдийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангаж ажилласан байна. Хүүхдийн нэгдсэн чуулган, хүүхдийг гэмт хэрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн хэлэлцүүлэг, Зүүн бүс нутгийн хүүхдүүдийн зөвлөгөөн зэрэг томоохон арга хэмжээнд Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд оролцож, аймгийн Засаг даргын нөөцийн сан болон аймаг хөгжлийн сангаас нийт 6.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2010 оны 12 сарын 14 ны өдөр Хүүхдийн төлөө зөвлөлийн хурал хуралдаж Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрт хийгдсэн үнэлгээг хэлэлцсэн байна. Аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө Зөвлөлийн дарга 2011 онд хүүхдийн парктай болох асуудлыг шийдвэрлэхээр болсон.

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн дуу хоолойг сонсох тэдний эрхийг хангах хамгаалах зорилгоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр ба бэлгийн мөлжлөг” сэдэвт сургалт зохион байгуулж, мэргэжлийн сургуулиудын 30 охид хамрагдан “Охидын клуб” байгууллаа. **“Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах цогц үйл ажиллагаа”** хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд сумдад хүүхэд хамгааллын дэд хөтөлбөрийн загвар бий болсноор хүүхэд хамгааллын стратегиа тодорхойлон ажиллаж байна. Мөн “ХХТХ-үүдийг устгах цогц үйл ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ажлын хэсгийнхэнтэй хамтран хүүхдийн хөдөлмөрийн чиглэлээр түншлэн ажилладаг 11 байгууллага, Аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 414 хүүхэд хөдөлмөрөөс бүр мөсөн хөндийрч, 301 хүүхэд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт аймгийн хэмжээнд 70 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009.12.04 өдрийн 70 тоот **тогтоолоор “Насанд хүрээгүй хүний асуудал эрхлэх хороо”-г**

байгуулж хорооны ажиллах журамыг батлан ажиллаж байна. Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийг бууруулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутаг болон олон улсын байгууллагуудад хандан хүсэлт гаргаснаар аймгийн ХХЗХ-ны үйл ажиллагаанд **аймгийн хөгжлийн сангаас 2,5 сая төгрөг**, НҮБ-ын **Хүүхдийн сангаас 3.295.0 мян төгрөгийн** санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. МУ-ын ХЭХТХуулийн 4.2, Хүүхдийн эрхийн конвенцийн 1.3.1, ЭБШХ – ийн 376 заалтыг үндэслэн гэмт хэрэг эрх зүйн зөрчилд холбогдсон хүүхдийг хүмүүжүүлж төлөвшүүлэхэд хамтран ажиллах зорилгоор цагдаа болон эцэг эх, хүүхдийн байгууллагын гурвалсан гэрээ байгуулан ажилласны үр дүнд гэмт хэрэгт холбогдсон 16 хүүхдийн ялыг хойшлууллаа. Гэмт хэрэг эрх зүйн зөрчилд холбогдсон 14 хүүхдийн байцаалтад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар оролцож мэргэжлийн дэмжлэг үзүүлэн шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж ажиллалав. Энэ бүхний үр дүнд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо аймгийн хэмжээнд 2010 онд **46.2** хувиар буурлаа.

Орон нутгийн хүүхэд, өсвөр үеийнхний шийдвэр гаргах түвшинд оролцох бодит оролцоог нэмэгдүүлэх, тэдний үзэл бодол, дуу хоолойгоо илэрхийлэх боломжийг дэмжих, хүүхдийн төлөө сайн засаглалыг бий болгох зорилгоор **“Сайн засаглалд хүүхдийн оролцоо”** төслийг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлээд байна. Хүүхдийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх, орон нутагт хүүхдийн төлөө сайн засаглалыг бий болгоход нөлөөлөх, дэмжлэг хүсэх зорилгоор зохион байгуулсан **“Хүүхэд хамгаалал ба хамтын ажиллагаа”** сэдэвт уулзалтад орон нутгийн солилцооны хөтөлбөрийн англичууд болон нутгийн удирдлагууд, нийгмийн салбарын төлөөлөл 30 хүн хамрагдлаа. Үүний үр дүнд Хүүхдийн минипарламент ажиллуулах санал дэмжигдэж ИТХ-ын дэргэд мини парламентын сайн загварыг 2011 онд туршихаар болсон. Монгол улсын Засгийн газрын 283 тоот тогтоолоор батлагдсан **“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих”** дэд хөтөлбөрийн хүрээнд **“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”** хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх, боловсролд хамруулах талаар асуудал хөндөгдөж улмаар 2010 онд 29 хүүхэд боловсролын үйлчилгээнд шинээр хамрагдсан нь өмнөх оноос 29 хүүхдээр нэмэгдсэн байна. Хүүхдийн нэвтрүүлгийн өдрийг тохиолдуулан **“Бид бусдын л адил”** сэдэвт хүүхдийн нэвтрүүлэг бэлтгэж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хүсэл мөрөөдөл, үзэл бодлыг олон нийтэд хүргэлээ.

Онцгой байдал, гамшгийн хүрээнд Аймгийн Засаг даргын зүгээс нийт 4 **ангийн 16 бүтээгдэхүүний хэрэгжилт 92 хувьтай** гарчээ. Нийлүүлсэн бүтээгдэхүүний явцаас харахад:

❖ **Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд:** Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын гамшгийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, сум орон нутагт тохиолдож буй гамшиг ослын үед ажиллах онолын болон практик мэдлэг олгох, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор **“Сумдын онцгой байдлын штабын дарга нарын сургалт, зөвлөгөөн”**-ийг 2010 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хэлтсийн

сургалтын танхимд 8 цагийн багтаамжтай зохион байгуулав. Энэхүү сургалтанд 14 сумын Тамгын газрын дарга, мэргэжилтэн 15 хүн хамрагдан оролцсон байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 31 аж ахуйн нэгж байгууллагын ажилчдад галын хэргийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 31 удаа 110 цагийн сургалтыг зохион байгуулан явуулж сургалтанд аж ахуй нэгж байгууллагын 689 ажилчид хамрагдан оролцож гал түймэр, гамшиг, аюулт үзэгдлийн үед өөрийгөө болон өмч хөрөнгөө авран хамгаалах анхан шатны мэдлэгийг эзэмшүүлсэн. Мөн Их дээд сургууль болон мэргэжил сургалтын төвийн оюутнуудад болон ЕБСургуулийн сурагчдад 2010 онд нийт 25 удаа 80 цагийн сургалт явуулан 1350 оюутан, сурагчдыг хамруулавгамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан байна. Хэлтсийн холбоо мэдээллийн бэлэн байдлыг хангахад тогтмол анхаарч, ОБЕГазрын шуурхай зохицуулагч, цонхлонтой тогтоосон цагуудад богино долгионы радио станц болон төрийн холбоо, интернетээр холбоонд орж мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулан ажиллаж байгаа ба цагийн байдалтай уялдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлгийг орон нутгийн “Шинэ суваг”, “ТВ-6”, “Гэгээ” телевизүүд, “Талын Монгол” богино долгионы радиогоор өдөрт 3-5 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, “Дорнод” сонинд нийтлүүлэн, Онцгой байдлын хэлтсийн www.dornod.mn /oba/ цахим хуудсанд байрлуулж ард иргэдэд мэдээлж байна.

❖ Гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах арга хэмжээний хүрээнд 2010 онд аймгийн хэмжээнд 11 сумын нутагт 19 удаа ой хээрийн түймэр гарч, сум орон нутгаас 1368 хүн, 236 тээврийн хэрэгсэл, Онцгой байдлын хэлтсээс 186 албан хаагч 15 тээврийн хэрэгсэл гарч ажиллан унтраасан байна.

Гамшигтай тэмцэх ажиллагаанд сум орон нутгийн мэргэжлийн ангиудын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийг сум, баг, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулан явуулсан. Аймгийн төсвөөс сумдын гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх зорилгоор 2010 оны төсөвт 14 суманд тус бүр 750.0 мянган төгрөгийн нөөц санг байршуулаад байна.

❖ **Аймгийн нөөц бүрдүүлэх, сэргээн босгох ажлын хүрээнд** 2010 онд Улсын нөөцөд өвс бэлтгэн нийлүүлэх тендерийг зохион байгуулж улсын нөөцөд 20000 боодол буюу 400 тн шинэ өвсийг бэлтгүүлэн нөөцлөөд байна

Монгол улсын Төрийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Улсын нөөцийн тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон ОБЕГазар, УНСБГазрын удирдлагын үүрэг даалгаврыг мөрдлөгө болгон төрийн албан хаагчийн сахилга бат, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, бараа материалын хадгалалт, хамгаалалт, сэлгэлт, шинэчлэлтийг хийх, галын аюулгүй ажиллагааг хангах, харуулын ажилтны сонор сэрэмжийг дээшлүүлэхэд үндсэн ажлаа чиглүүлэн ажиллаж байна. УНСалбарын хувьд санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхаарвал зохих үндсэн чиглэл нь өр, авлага барагдуулалтын ажил байгаа тул сэргээн босгох чадамжийг сайжруулахаар хуучин өр

авлагаас 1.6 сая төгрөгийн авлага барагдуулан ажиллаж цаашид 41.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээр өр авлагыг барагдуулахаар ажиллаж байна.

ХОЁР. БАТЛАН ХАМГААЛАХ САЙД

Аймгийн Засаг дарга **4 бүтээгдэхүүний 16 нэр төрлийн зорилтуудыг 95 хувьтай** нийлүүлсэн байна. Бүтээгдэхүүний хэрэгжилтээс дурьдвал:

➤ **Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгжилтэд нь хяналт тавих** ажлын хүрээнд Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах зорилгоор Аймгийн Батлан хамгаалах газрын даргын нэрэмжит үзлгийг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Баяндун, Дашбалбар, Чойбалсан зэрэг 3 сум, Хэрлэн сумын 12 байгууллага аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан байна. Шалгалтаар цэргийн тоо бүртгэл завсардсан, цэрэг татлагаас зайлсхийсэн мөнгөн төлбөр төлөөгүй, цэргийн дүйцүүлэх албанд хайнга хандсан 60 гаруй иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна. Монгол Улсын дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сумдын Засаг дарга нар болон Тамгын дарга нарын цэрэг- стратегийн бэлтгэл сургалтыг тус бүр 2 хоногийн хугацаатайгаар аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулжээ. Аймгийн 14 сумдын 58 багийн Засаг дарга нартай цэргийн бэлтгэл сургалтыг 1 өдрийн хугацаатай сумдаар бүсчлэн явуулж Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах талаар лекц, ярилцлага зохион байгуулсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 89 жилийн ойн баярыг угтаж дараахь ажлуудыг зохион байгуулж Төр нийгэм цэргийн нэрт зүтгэлтэн хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит “Марш, тактик тусгай бэлтгэл”-ийн аварга салаа, тасаг шалгаруулах тэмцээнийг Дорнод аймгийн “Чойбалсан” цэргийн хүрээний анги, салбар, байгууллагуудын дунд зохион байгуулж уг тэмцээнд 9 анги байгууллагуудын 10 баг тамирчид оролцлоо.

Аймгийн хэмжээгээр Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд хамрагдах 18-50 насны 20614 эрчүүдээс 17946 эрчүүд буюу 87 хувь нь хамрагдсан бөгөөд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоог өмнөх жилтэй харьцуулахад бэлтгэл офицер 7 хүнээр, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэнгүүд 342 хүнээр өсч, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 663 хүнээр, хаягандаа байхгүй хүний тоо 56 хүнээр тус тус буурч бүртгэгдсэн байна.

Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9-ийн 3 дугаар зүйл, Засгийн газрын 2010 оны 75 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжийг үндэслэн энэ оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулжээ.

Цэрэг татлагад хамрагдах 18-26 настай 1152 цэргийн насны залуучууд цэрэг татлагын товчооны үзлэгт хамрагдаж 289 иргэн нь буюу 25 хувь нь эрүүл мэндээр цэргийн жинхэнэ албанд тэнцэж, 863 иргэн нь буюу 75 хувь нь биеийн эрүүл мэндээр цэргийн албанд өвчний учир тэнцэхгүй чөлөөлөгдсөн байна. Үүнээс дотор, чих хамар хоолойн өвчлөл зонхилж байна.

Гэрээт цэргийн албанд сайн дураараа элсэн залуучуудын тоо өнгөрсөн оноос 11 хүнээр нэмэгдсэн байна.

Монгол Улсын Их хурлын 2009 оны 33 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэргийн албыг ямар нэгэн хэлбэрээр орлуулан хаагаагүй 27 нас хүрсэн 82 иргэнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгахаар аймгийн Засаг даргын захирамж гаргаж 14.4 сая гаруй төгрөгийн төлбөрийг тогтоож 11.3 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж мөн дээрх хууль тогтоомжийг үндэслэн 123 иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаахаас чөлөөлсөн болно.

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн 11.3 сая төгрөгийн тавин хувь болох 5.6 сая төгрөгийг Батлан хамгаалах яамны “Зэвсэгт хүчний шинэчлэл” төв төрийн сангийн дансанд шилжүүлээд байна.

❖ Дайчилгааны төлөвлөгөөг тодотгож, баталгаажуулах, даалгаваржуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах зорилгоор Батлан хамгаалахын сайдын 400, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 400/01, 400/02 дугаар удирдамж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын н/20 дугаар албан даалгаврын хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулсан сургалтын тайланг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт зохих журмын дагуу хүргүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний 327 дугаар анги, 085, 329 дүгээр салбаруудтай дайчилгааны даалгавраар оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэнг нэрсээр, автотехникийг маркаар тодотгох ажлыг тогтмол явуулж байна.

Түүнчлэн цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн үеэр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Хэрлэн сумын багийн Засаг дарга нар, Зэвсэгт хүчний 327, 329, 085 дугаар анги, салбаруудын захирагч болон бусад офицеруудтай хамтран дээрх ангиудын командуудад оногдуулан данслагдсан цэргийн бэлтгэл үүрэгтнийг мэргэжлээр, техникийг маркаар нь тус тус тодотгож, нөхөн хангах ажлыг зохион байгуулж явуулаа. Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 21 дүгээр зүйл, Дайчилгааны тухай хуулийн 5 дугаар бүлгийн 29 дүгээр зүйлийг үндэслэн аймгийн Засаг даргын 41 дүгээр захирамжаар нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний бүрэлдэхүүнээс 80 цэргийн бэлтгэл үүрэгтэнгүүдийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад сургах арга хэмжээг зохион байгуулж явууллаа.

Сургалтад хамрагдсан Бэлтгэл офицеруудыг команд – 7020-д , нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг дараахь, анги, командуудад шинээр оногдуулан дансаллаа. Үүнд: 5353 ,7790 .6349, 5767, командуудад тус бүрт нь оногдуулан дансаллаа.

Сургалтад оролцсон бүрэлдэхүүн 80 цагийн хичээлийн программ хангаж лекцээр 30, дадлагаар 50 цагийн сургалт явуулан төгсөлтийн шалгалт, шүүлэг авч хүн нэг бүрээр нь дүнг гаргаж ажиллалаа.

Сургалтад оролцсон бүрэлдэхүүн 120 цагийн хичээлийн программ хангаж онолоор 60, дадлагаар 60 цагийн сургалт явуулан төгсөлтийн шалгалт, шүүлэг авч хүн нэг бүрээр нь дүнг гаргаж дүгнэсэн байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЗҮЙН ДОТООД ХЭРГИЙН САЙД

Аймгийн Засаг даргаас Хууль зүй дотоод хэргийн сайдтай 2010 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг дараах зорилт бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр гэрээг байгуулсан байна. Нийлүүлэх гэрээг бүлэглэвэл удирдлага зохион байгуулал 8, Гэмт хэрэгтэй тэмцэх 7, Нийгмийн хэв журмыг хамгаалах 6, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 12, Тусгай захиалгат 5, Өмчлөгийн эрхийг хэрэгжүүлэх 2, **НИЙТ 6 ангийн 40 бүтээгдэхүүнийг 90 хувьтай** нийлүүлсэн байна. Тухайлбал:

❖ Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд

Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга, Хууль зүйн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон сумдын өөрө удирдах байгууллага, засаг даргад аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулга, мэдээлэлийг сар тутам хүргэж, танилцуулан нутгийн өөрөө удирдах болон төрийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг оновчтой зохион байгуулах бололцоо нөхцөлийг хангаж хамтран ажилласанаар ажлын үр дүнд ахиц гарч Дорнод аймагт эхний 2010 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаар 451 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 17.3 хувь буюу 94 хэргээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2010 оны байдлаар 526 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 18,5 хувь, 115 пунктээр буурсан байна. Үүнээс дараах тодорхой төрлийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: Бусдын өмчийг хулгайлах гэмт хэрэг 24,6 хувь /60 пунктээр/, иргэдийн өмчийг хулгайлах хэрэг 22,4 хувь /25 пунктээр/, мал хулгайлах гэмт хэрэг 46,1 хувь /59 пунктээр/, танхайрах гэмт хэрэг 8,9 хувь /6 пунктээр/, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг 47,3 хувь /17 пунктээр/ буурсан байна.

Үйл ажиллагаандаа тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашигладаг БНХАУ-н хөрөнгө оруулалттай холимог металын “Шинь шинь” ХХК, “Шан-Лун” ХХК, газрын тосны “Шан-Лун” ХХК-дад улиралд нэг удаа, нэгдсэн арга хэмжээний хүрээнд

нэг удаа Мэргэжлийн хяналтын газартай хамтран явуулж тэсрэх материаллын хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтын стандарт, зарцуулалт, тайлан гаргалт, тэсрэх материалын үлдэгдэл, гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа энэ талаар төрөөс гаргасан эрх зүйн актын хэрэгжилтэнд хяналт шалгалт явуулж мэргэжлийн хяналтын байцаагчийн акт, дүгнэлт, шаардлага тус бүр нэгийг бичиж илэрсэн зөрчлүүдийг засах хугацаатай үүргийг өгч биелэлтийг тооцож байна.

❖ **Нийгмийн хэв журам хамгаалах**

Аймаг орон нутгийн эрүү болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж, 14 хоногт 1 удаа төрөл мэргэжлийн албадыг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгмийн хэв журам сахиулах ажлын чиглэлээр эргүүлд нэмэгдлээр томилж ажиллуулах, хүн ам техник хэрэгслийн хөдөлгөөн ихсэх баяр ёслол, нийтийг хамарсан арга хэмжээний үед байгаа хүч хэрэгслээ төвлөрүүлэн шөнийн машинт эргүүл, хөдөлгөөнт 24 цагийн эргүүл, шалгалтыг тогтмол зохион байгуулж, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг явуулж, гарсан хэрэг зөрчлийг шуурхай шалгаж шийдвэрлэж ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн байдалд 7 хоног, сар улиралаар дүгнэлт хийж тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр өөрсдийн хүч бололцоогоор болон бусад алба тасаг, аймаг, сумын Засаг даргын тамгын газартай хамтран албан байгууллага аж ахуйн нэгжийн хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор “ Орцны жижүүр”, “Хяналт”, “Банк”, “Хяналт шалгалт”, “Архи- Спирт”, “Шаг”, “Хутга мэс”, зэрэг Нэгдсэн, Тусгай, Нэгбүрчилсэн арга хэмжээг тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу 24 удаа зохион явуулж, гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах талаар иргэд, баийгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтанд мэдэгдэл, шаардлага 46 хүргүүлж 23 хариуг авч ажиллаа.

Улирал, сар бүр эрүү, хэв журмын нөхцөл байдлын танилцуулыг гарган авч хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн санал дүгнэлийг аймгийн удирдлага, ЦЕГ-н НХЖХГ-т журмын дагуу хүргүүлж эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн, хүндрэх төлөвтэй үед Цагдаагийн газрын даргын тушаал, аймаг, сумын Засаг даргын захирамжийг тухай бүрт нь гаргуулан ЦГ-н бусад тасаг албад, иргэд, төсвийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг гэмт хэрэгтэй тэмцэх, НХЖХ-х ажилд татан оролцуулсан

❖ **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх**

Сүүлийн 5 жилд аймгийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа, дүгнэлт хийж тодорхой төрлийн гэмт хэргүүдийн өсөлт, түүний шалтгаан нөхцөлийг тогтоож энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр /тухайлбал: аймгийн хэмжээнд өссөн үзүүлэлтэй байгаа малын хулгайн гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг/

оруулах саналыг аймгийн ИТХурлын даргад хүргүүлж, хийх ажлын төлөвлөгөөнд тусгуулан төлөвлөгөө хувиарийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. .

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, эрчимжүүлэх, сан байгуулах чиглэлээр сумдын ИТХ, засаг дарга нарт 2 удаа мэдээлэл хийж , санал солилцсон. Аймгийн ГХУСАЗСЗ-д малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх санг шинэчлэн байгуулах төсөл хүргүүлж батлуулав.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санг шинэчлэн байгуулах, төсөл саналыг бүх сумдын ИТХ, засаг дарга, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж ажиллах ажлын зааварчлага, чиглэлийг бичгээр хүргүүлж сар бүр үр дүнг тооцон ажиллаж байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Цагдаагийн газраас “Эрчимжүүлэлт”, “Илрүүлэлт, Оргодол-2010”, “Хяналт” “Малын хулгай, ченж” зэрэг нэгдсэн болон тусгай арга хэмжээг тодорхой үе шаттайгаар удирдамж төлөвлөгөөний дагуу явуулж хэрэгжүүлж ажилласны үр дүнд мал мах, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг зах, 78 ченжийн зурагжуулсан судалгааг шинэчлэн авч бүх ченжийн судалгааг санд оруулан, Цагдаагийн хяналтанд авч энэ төрлийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 40 хувиар буурсан байна.

Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа, гэр бүл хүчирхийлэл, ДОХ-той тэмцэх, хүний эрхийг хангах, хүмүүнлэгийн чиглэлээр орон нутагт явагдсан давтан сургалтанд төлбөргүйгээр 43 цагдаагийн алба хаагч хамрагдаж орон нутгийн төр захиргааны байгууллагаас 7 удаагийн сургалт зохион байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллаж байна. Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх ажилд алба хаагчдыг мэргэшүүлэхэд анхаарч, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажилласны үр дүнд 2010 оны эхний 10 сарын байдлаар бүртгэгдсэн хэргийн 3.4 хувийг гэр бүлийн хүчирхийллийн хэрэг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 27.3 хувь буурсан үзүүлэлттэй байна.

Архидан согтуурахтай тэмцэх ажилд төр захиргаа олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоо нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирсны үр дүнд 2010 оны эхний 10 сард бүртгэгдсэн хэргийн 29.9 хувийг буюу 135 хэргийг архидан согтуурсаны улмаас үйлдэгдсэн өнгөрсөн оны мөн үеийн хэрэг зөрчилтэй харьцуулбал 17.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлаар заавар зөвлөмж, санамж анхааруулга 132-ийг боловсруулж хүн олноор цуглардаг газрууд, мэдээлэл сурталчилгааны самбар, худалдаа, үйлчилгааний газруудаар болон өдөрлөг арга хэмжээний үеэр 7800 ширхэгийг тарааж, иргэд олон нийтийн санаа бодлыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тусгах зорилгоор санал асуулгын хуудсаар, хайрцгаар бичгээр 14 сумын 4000 иргэнээс санал хүсэлтийг авч, хийх ажлын төлөвлөгөөнд нэмж тусган иргэд олон нийттэй хамтарч ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлж, түүний 5.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг иргэдэд хууль сурталчлах арга хэмжээнд зарцуулна” гэсэн заалтын дагуу Цагдаагийн газраас батлагдсан төсвийн 7 хувь буюу 4960.6 хуийг иргэд аж ахуйн нэгж байгууллагад хууль сурталчлах үйл ажиллагаанд зарцуулжээ.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Төсвийн ерөнхийлөн захирагч Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдаас аймгийн Засаг даргатай 2010 онд 4 бүлгийн 24 стратегийн арга хэмжээг нийлүүлэх гэрээг байгуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар бүтээгдэхүүний хэрэгжилт **92 хувьтай** байна. Хэрэгжүүлсэн ажил арга, хэмжээний хүрсэн үр дүнгээс танилцуулбал:

Сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд хувилбарт сургалт зохион байгуулсны дүнд сургуульд элсэх насны хүүхдийг 100 хувь сургуулийн өмнөх боловсролд хамруулсан. Бага боловсролын амжилт 99.1, суурь боловсролын амжилт 99.4, бүрэн дунд боловсролын амжилт 99.6 болж боловсролын үндсэн үзүүлэлт улсын дундаж үзүүлэлтэд хүрсэн.

Аймгийн Засаг дарга үйл ажиллагааныхаа хөтөлбөрт тусгагдсан “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгон өргөжүүлэх зорилтын хүрээнд Сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн аймгийн “Хяналтын зөвлөл” ажиллууснаар нийт сургууль, сургуулийн гал тогоогоор эрүүл, чанартай хоол хүнс бэлтгэн өгч “Үдийн хоол” болгох зорилт 95 хувьтай биелж 2010 онд 476940.0 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг “Дорнод дээд сургууль”, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Шаталсан сургалттай техник технологийн сургуулиуд нь Зүүн бүсийн аймгуудын оюутан залуучуудыг сурган, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн хувь нэмрээ оруулж байна.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “2010 оныг Соёлын жил” болгон зарлаж, “Нар тоссон нутаг” нэртэй сум сурталчлах соёлын өдрүүдийн арга хэмжээг Чойбалсан хотноо амжилттай зохион байгуулсан нь хөдөөгийн соёлын урлагийн үйлчилгээний чадавхи, хөгжлийг сурталчилсан үйлчилгээний өргөн хүрээг хамарсан үр дүнтэй ажил болжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.4-т “Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг эх, асран хамгаалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2010 онд 13-н

сумын 18 багт хичээллэж нийт 326 хүүхэд сургалтанд хамрагдсаны 38 хүүхэд ээлжийн бүлэгт, явуулын багшийн сургалтанд 20, нүүдлийн сургалтанд 278 хүүхэд тус тус хамрагдсан байна.

Сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэх үүднээс 5-н настай хүүхдийн судалгааг гарган, цэцэрлэгт хамрагдаагүй 5-н настай хүүхдийн эцэг эхчүүдэд хүүхдээ сургуульд хамруулах мэдэгдэл өгч ажилласнаас гадна сургуульд хамрагдах боломжгүй малчдын хүүхдийг хувилбарт сургалтаар хамруулсны дүнд сургуульд элсэх насны хүүхдийг 100 хувь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаад байна.

Ерөнхий боловсролыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх, багш нарыг бэлтгэх, төлөвлөгөө хөтөлбөрийг шинэчлэх үйл явц эрчимтэй хийгдэж байна.

Хамран сургалтын талаар аймгийн ЗД-аас сумын ЗД нартай хийсэн үр дүнгийн гэрээнд тусган тооцож ажилласнаар 2010 -2011 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 0,7 хувиар суурь боловсролын хамрагдалт 1.2% өссөн.

- 2010 онд 1964 багш мэргэжил арга зүйгээ дээшлүүлсний дотор 12 жилийн сургуулийн нэгдүгээр ангид хичээл заах 52 багшийн мэргэжил, арга зүйг дээшлүүлсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын стандарт хангалт бага бүлэгт 84, дунд бүлэгт 91, ахлах бүлэгт 87, бэлтгэл бүлэгт 91 хувьтай дүгнэгдсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн жилийн эцсийн сурлагын амжилтын дүнд анализ хийхэд 5 дугаар ангийн Монгол хэлний хичээлийг өмнөх онтой харьцуулахад амжилт 98 буюу 0.6 хувиар, чанар 51 буюу 1.2 хувиар өссөн, Математик амжилт 0.7 хувь, чанар 1.7 хувь өссөн.

Сурлагын амжилтын үнэлгээг анги хичээл бүрээр хийж дүгнэлт хийсэн. Бага боловсролын хувьд нийт 13 хичээлээр сурлагын амжилтыг дүгнэхэд амжилт 99.1, чанар 67.5 хувь, суурь боловсролын түвшинд 19 хичээлээр дүгнэхэд амжилт 99.4, чанар 59.4, бүрэн дунд боловсролын түвшинд 14 хичээлээр дүгнэхэд амжилт 99.6, чанар 69.4 хувьтай шалгагдсан бөгөөд улсын дундажтай харьцуулахад хангалттай байна.

Монгол улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс 2007 оны 6 дугаар сард Дорнод аймгийн боловсролыг хөгжүүлэх урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулсан. Уг төлөвлөгөөг 2008 онд дахин шинэчлэн боловсруулж жил бүр уг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 24 дотуур байр үйл ажиллагаа явуулж, нийт 1278 хүүхдэд үйлчилж байгаа ба эдгээрээс 57 хувь нь буюу 728 нь малчдын хүүхэд байна.

2010 онд БСШУЯ-ны 4.0 сая төгрөгийн санхүүжилтээр Чулуунхороот сумын ЕБС-ийн дотуур байрны халаалтын зуухыг “Сүхжин” ХХКомпани шинэчлэн засварлаж, хугацаанд нь гүйцэтгэсэн ба Гурванзагал сумын ЕБС-ийн сурагчдын дотуур байрны засварыг “СОД MN” ХХК гүйцэтгэж, байрны дотор монтаж, сантехникийн ажлыг хийж дулаан тохилог орчин бүрдүүлээ. Мөн Сэргэлэн сумын сургуулийн дотуур байрны дээвэрт засвар хийсэн. Олон нийтийн санаачлага бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2010 онд “Тогтвортой амьжиргаа 2” төслөөс Гурванзагал суманд “Цэвэр орчин”, Дашбалбар суманд “Миний байр”, Чулуунхороот суманд “Дулаан орчин” зэрэг дотуур байрны засвар үйлчилээ хийж тохижуулсан. Уг ажлын хүрээнд Дашбалбар сум 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 дотуур байрыг засварласан бол Булган суманд иргэд эцэг эхийн санаачлагаар 11565,6 мянган төгрөгийн дотуур байрны засвар хийж тохижууллаа.

БСШУ-ны сайдын хөрөнгө оруулалтаар Цагаан-Овоо сумын сургуулийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийн сэлбэгт 2.0 сая төгрөгийг зарцуулаад байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах арга зүй” цуврал сургалтыг 2010 онд 5 удаа зохион байгуулж, 160 багшийг хамрууллаа. Сургалтаар оюуны болон ой тогтоомжийн үнэлгээ, оюуны өсөлт, хөгжлийн талаарх харьцуулсан судалгаа хийх аргад суралцаж, оюуны хөгжлийн талаарх судалгааны сан бүрдүүлэх эхлэл тавигдлаа. Шинэ хичээлийн жилд Хэрлэн сумын төрийн 9 сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний багш нарт зөвлөн туслах хуваарийг гарган, 10 сарын 4-өөс эхлэн сургууль дээр ажиллаж байна. Тулах эрхтэний бэрхшээлтэй 2 хүүхдэд тэргэнцэр, 2 хүүхдэд сандал, 1 хүүхдэд ширээ, 1 хүүхдэд булангийн сандал, 1 хүүхдэд булчингийн бэрхшээл засах сандал олгов. Гарын доорх материал ашиглан тоглоомын нөөц хэрэглэгдэхүүн бэлтгэх сургалтыг ХБХЭЭХ-ны 10 ээжид, морин засалын арга сургалтыг 40 эцэг эхэд зохион байгуулав. Булчингийн /чангарлын хаталт/ сайжруулах технологи – EMM-Tech сургалтыг 10 зөвлөх ээжид зохион байгуулав.

2009-2010 оны хичээлийн жилд улсын төсөв болон төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр сургууль 25 сая, Цагаан-Овоо сумны дотуур байр, мөн “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн хүрээнд Хан-Уул цогцолбор сургууль, Баян-Уул, Дашбалбар сумын сургуульд тус бүр 9.680.000 төгрөгний гал тогооны тоног төхөөрөмж, орон нутгийн төсвөөс буюу “Тогтвортой амьжиргаа-2” хөтөлбөрөөс Баянтүмэн сумын сургуулийн гал тогоонд 2.062.000, Матад сумын ЕБС-д 4.928.000, Хөлөнбуйр сумын ЕБС-д 5.130.000, Чойбалсан сумын ЕБС-д 9.763.000 төгрөгийн гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр нийт сургууль сургуулийн гал тогоогоор үдийн цай өгч “Үдийн хоол” болгох зорилт биеллээ.

Тус аймагт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг “Дорнод дээд сургууль”, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Шаталсан сургалттай техник технологийн сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд дээрх сургуулиудаар дамжуулан

Дорнод аймгийн төдийгүй Зүүн бүсийн аймгуудын оюутан залуучуудыг сурган, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байна.

“Дорнод дээд сургууль”-аас ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг дахь сурган хүмүүжил болон түүх соёлын судалгааны зөвлөлийн хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх, Хятад хэлний сургалт зохион байгуулах, чанартай мэргэжилтэн бэлтгэхэд хамтран ажилладаг бөгөөд энэ ажлын хүрээнд 2010 оны зуны амралтаар 2 сарын хугацаанд 35 оюутан хэлний дадлага хийхийн зэрэгцээ аялал жуулчлалын баазууд дээр ажиллах нөхцөлийг хангаж ажиллаа. Мөн орон нутгийн ЕБС-иудтай хийсэн дадлагын гэрээний дагуу 3-4 дүгээр курсийн оюутнууд дадлага ажлыг амжилттай хийсэн байна.

Шаталсан сургалттай техник технологийн сургуулиас Матад суманд үйл ажиллагаа явуулж буй Газрын тосны “Петро Чайна Дачин Тамсаг Монгол” компанид ажиллаж буй гадаад ажилчдын тоог цөөрүүлэх зорилгоор тус сургуулиар захиалгаар бэлтгэн гаргаж буй газрын тосны операторын мэргэжлийн ангийн төгсөгчдийг ажилд бүрэн хамруулах талаар компанид шаардлага тавин ажиллаж байна.

2010 онд нийтийн биеийн тамир, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсөвт 30 сая төгрөг тусгуулан 9 орон сууцны гадаа талбайд чийрэгжилтийн гүйлтийн зам, сэтгэл зүйн зурвас, хэвтээ шахалт, түрник, суга савлуур, хөл савлуур, гар сэлүүр, дүүжин, гэдэсний таталт зэрэг хэрэглэл материалыг байрлуулан зун, хавар, намрын цагуудад иргэд хөдөлмөрчид өөрийн бие, насны онцлогт тохирсон хэрэглэл дээр дасгал хөдөлгөөнийг хийж заншаад байна.

Номын сангийн суудлын тоог нэмэгдүүлэх зорилгоор Хөлөнбуйр Баян-Уул, Баянтүмэн, Матад, Булган сумдын соёлын төвдүүдэд 2010 оны 10 сард нийт 2.337.500 төгрөгийн ширээ сандалыг нийлүүлээ. Соёл урлагийг хөгжүүлэх сангаас ном худалдан авах зардалд зориулж олгосон 2533000 төгрөгөөр 356 төрлийн шинэ ном, 1, 2, 3 дугаар улиралд 19 төрлийн 492000 тогтмол хэвлэл, хандив тусламжаар ирсэн 1,224,671 төгрөгийн 315 номоор фондоо баяжуулсан. Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг “Номын яармаг-2010” аяныг угтаж зарласан “Иргэн бүр нэг ном” сарын хугацаанд 933 ш ном хандивласнаас хэрэгцээт 352 номыг уншлагын танхимуудад өгч, үлдсэн номыг сумдын номын сангуудад хүргүүлсэн. Шилдэг номд шалгарсан 201 төрлийн 19997500 төгрөгийн номыг 13 сумын нийтийн номын сангуудад хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “2010 оныг Соёлын жил” болгон зарлаж, “Нар тоссон нутаг” нэртэй сум сурталчлах соёлын өдрүүдийн арга хэмжээг Чойбалсан хотноо амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь сум орон нутгийн өв соёлын онцлогийг хамгаалах, сэргээн хөгжүүлэх, ололт амжилтыг нь аймаг, улсын хэмжээнд таниулан сурталчлах, хойч үедээ өвлүүлэх, өссөн төрсөн өлгий нутаг, уул усаараа бахархах сэтгэгдлийг ард нийтэд төрүүлж төлөвшүүлэхэд үр дүнтэй, ач холбогдолтойн дээр хөдөөгийн соёлын урлагийн үйлчилгээний чадавхи, хөгжлийг

сурталчилсан үйлчилгээний өргөн хүрээг хамарсан үр дүнтэй ажил боллоо.

“Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймагт эртний хот суурин, сүм хийдийн туурь, булш хиригсүүрийг хууль бусаар малтах ажлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 265 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийлээ.

“Уртын дуу-Морин хуур”-ын зөвлөл, Аймгийн Хэрлэн сумын ЗДТГ, ХДТ, Хөгжмийн мэргэжлийн сургалттай 12 дугаар сургууль зэрэг байгууллагуудтай хамтран “Монгол ардын богино болон уртын дуу”-ны бага наадмыг зохион байгууллаа. Бага наадам нь Ардын болон уртын дуу гэсэн 2 үе шаттай явагдаж, аймаг хотын нийт 56 ардын авъяастан, хүүхэд багачууд үр чадвараа сорин амжилттай оролцлоо. Шалгаруулалтын явцад шүүгчдийн онооны жагсаалтаар уртын дууны төрлөөс 2-р шатанд 8 оролцогч, ардын богино дууны төрлөөс 13 оролцогч оролцож амжилттай зохион байгуулагдсан.

“Монгол Хөөмий” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн хөгжмийн хичээлийн стандартын агуулгад хөөмийн талаарх ойголтыг тусган оруулж, багш нарын дунд “Цахим ээлжит хичээл”-ийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд нийт 9 сургуулийн 12 багш, 6-9 ангийн нийт 360 суралцагчдад хөөмийн урлагийн талаарх танин мэдэхүйн мэдлэг мэдээллийг олголоо. Тус уралдаанд багш нар интернетээс мэдээлэл цуглуулан боловсруулалт хийн ээлжилт хичээлийг цахим хэлбэрээр зааж байгаагаараа онцлогтой. Уралдаанд амжилт үзүүлсэн багш нарын ээлжит хичээлийн боловсруулалтыг блог дээр тавин бусад багш нарт сурталчлан түгээлээ.

Монголын уламжлалт ардын урлагийн өв сан үндэстэн ястны бий биелгээний талаарх мэдээллийг залуу үедээ өвлүүлэн залгамжлуулах, хүүхэд багачуудын авъяас билгийг нээн илрүүлж хөгжүүлэх, тэдэнд гоо зүйн хүмүүжил олгох, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Аймгийн ЕБС-ын хөгжмийн багш, Сумдын соёлын төвийн хөгжим, бүжгийн багш нарт “Бий биелгээ” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, “Чадварт суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах” зэрэг сэдвээр сургалтыг 2010 оны 03 сард БСГ-т зохион байгууллаа. Сургалтанд хөдөө орон нутгийн нийт 59 багш хамрагдасны үр дүнд багш нарт явуулсан сургалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар Уламжлалт бий биелгээний талаар мэдлэг эзэмшүүлэх, танин мэдэхүйн олон үйл ажиллагааны үр дүнд ардын урлагийн сонирхон хичээлэх суралцагчдын хамрах хүрээ нэмэгдэж байна.

Дорнод аймгийн музей нь Монгол Усын Засгийн газрын “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага стандартын 12.7.2, БСШУ-ны сайдын 2009 оны 257

дугаар тушаалыг үндэслэн, Музейн захирлын 2010 оны 02 дугаар тушаал гарч комисс томилогдон, түүх, соёлын дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, соёлын өвийн бүртгэл-ерөнхий бүртгэлийн дурсгал бүрийг маягтын дагуу хувийн дугаар, зургаар тулгаж үзэх, унасан, бүдгэрсэн дурсгалын хувийн дугаарыг сэргээх гэсэн 5 чиглэлийг баримтлан ажилласнаар нийт 1470 дэсийн дугаар бүхий 3386 ширхэг үзмэр эд өлгийн зүйлийг тулгаж тоолж, музейн нийт үзмэрийг бүртгэн баримтжуулж бүртгэл мэдээллийн санг бүрдүүллээ. Соёлын өвийн бүртгэн баримтжуулах “RCH” програмд өөрийн музейн нийт үзмэрийн 88 хувийг бүртгэн, үзмэрийн гэрэл зургийг стандартын дагуу авч Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд илгээн цахим мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд сумдын соёлын төвийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд хөгжим, техник хэрэгслээр хангахад зориулан 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна. Тогтвортой амжиргаа төслөөр Хөлөнбуйр сумын соёлын төвд 2010 оны 4 сард барилга засвар материаллаг баазыг бэхжүүлэхэд 39,9 сая төгрөгийн хөрөнгө хийгдсэн. Чойбалсан сумын Соёлын төвийн барилгыг улсын төсөв болон БСШУЯ-ны сайдын багцаас нийт 102.0 сая төгрөгөөр засварлаж дуусгасан

Хүн амд үйлчлэх соёл, урлагийн хүртээмж чанарыг нэмэгдүүлэх, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 3 тэрбэм төгрөгийн өртөгтэй аймгийн Хөгжимт драмын театрын барилгыг 2009 оноос шинээр барьж эхэлсэн бөгөөд 2009 онд 700.0 сая төгрөгийн, 2010 онд 1.0 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын ажил хийгдээд байна.

Аймгийн Төв номын санд Соёл урлагийг хөгжүүлэх сангаас 2010 онд ном худалдан авах зардалд 2533000 төгрөг олгосноор 356 төрлийн шинэ ном, 492000 тогтмол хэвлэл, хандив тусламжаар 1,224671 төгрөгийн 210 нэр төрлийн 315 номоор фондоо баяжуулан нийт 71000 номоор фондоо баяжуулсан.

“Шилдэг ном 2009”-д шалгарсан 201 төрлийн 1997500 төгрөгийн номыг 13 сумын нийтийн номын сангуудад хүргүүлж ажилласан. Мөн 10 дугаар сард БСШУЯамны хөрөнгө оруулалтаар Баянтүмэн, Матад, Хөлөнбуйр, Чойбалсан, Булган сумын соёлын төвийн номын санд нийт 2.337.500 төгрөгийн сандал ширээг нийлүүллээ. 2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төв номын сангийн өргөтгөлийн зураг төсөвт 10 сая төгрөг батлагдсаны дагуу аймгийн үнэлгээний хороо тендер зарлаж “ДОЗТ” ХХК шалгарч зураг төсвөө хийж хүлээлгэн өгөөд байна.

Мөн аймгийн Музейн 60 жилийн ойг тохиолдуулж 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр музейн Г.К.Жуковын командын байрыг тохижуулж, 1 ширхэг иж бүрэн компьютертэй болгоод байна. Мөн Халхгол сумын Ялалт музейг 5.0 сая төгрөгөөр хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Аймгийн Засаг даргаас Эрүүл мэндийн сайдад 2010 онд нийт 3 бүлгийн 16 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний бүтээгдэхүүн, нийлүүлэх, санхүүжилтийн гэрээг байгуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар **85 хувийн** хэрэгжилттэй дүгнэгдлээ:

Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний биелэлтээс харахад:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилтын нэг болох эрүүл мэндийн салбарын хөгжлийн үндэс суурийг бэхжүүлэх, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, хангамжийг сайжруулах, алсын зайн эмчилгээ, оношлогооны олон улсын төслүүдийг амжилттай хэрэгжүүлж 2010 оны дэвшүүлсэн зорилтын хүрээнд **298.988.751 төгрөгийг** зарцуулсан байна. Тус салбарын хүрээнд хийгдсэн ажлын явцаас харахад:

➤ Эрүүл мэндийн салбарийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2010 оны байдлаар 298.988.751 сая төгрөгийг зарцуулсан байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний гурав дахь хөтөлбөрийн дагуу Мянганы хөгжлийн зорилтын Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулж, эрүүл эхээс эрүүл хүүхэд зарчмыг эмнэлгийн тусламж үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлснээр **2009-2010 онд эхийн эндэгдэлгүй** ажиллажээ. Жирэмсний эхний гурван сарын хяналт энэ онд 1621 буюу 81,1 хувь болж өнгөрсөн оныхоос 3 хувиар өссөн. Эхийн амрах байранд амарсан эхчүүдийн тоо 311 буюу 49,6 хувь өнгөрсөн оноос 5,0 хувиар, эмнэлэгт төрсөн эхчүүдийн эзлэх хувь 1836 буюу 99,7 хувь болж 0,4 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.,

➤ **Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах** зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 3.8 болж өмнөх оныхоос 1.5-аар өссөн, нялхсын эндэгдэл 17 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөнд 10.2 байна. УГУ- н хавсарсан шинэ вакцинд 3430 хүүхэд хамрагдахаас 3419 хүүхэд хамрагдаж хамралт 99.7% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,3 хувиар буурсан

➤ **Алслагдсан хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх явуулын эмнэлгийн тусламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд”** зорилтын дагуу Хөлөнбуйр, Цагаан-овоо , Сэргэлэн сумын эмнэлэгт тус бүр 18.3 сая төгрөгийн өртөг бүхий УАЗ 469 автомашин, Баяндун сумын эмнэлэгт Тогтвортой амьжиргаа төслөөс шинэ автомашиныг тус тус олгосон байна. Өрхийн эмнэлгүүдэд тус бүр нь 16.5 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг Nissan Extral маркийн автомашиныг олгосон. Мөн 120 сая төгрөгийн үнэ бүхий зайлшгүй шаардлагатай оношлогоо, эмчилгээний болон мэдээ, мэдээллийн тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн төвийн сумын 3 өрхийн эмнэлгүүдийг цахим сүлжээнд холбох ажлыг эхлүүлэх үүднээс G mobile-ийн интернэтийн модемоор хангагдсан байна.

➤ “Нийтийн биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээ авах тухай” –ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилт дэвшүүлэн орон нутгийн төсөвт 30 сая төгрөг тусгуулан 9 орон сууцны гадаа талбайд чийрэгжилтийн гүйлтийн зам, сэтгэл зүйн зурвас, хэвтээ шахалт, түрник, суга савлуур, хөл савлуур, гар сэлүүр, дүүжин, гэдэсний таталт зэрэг хэрэглэл материалыг байрлуулсан бөгөөд Биеийн тамир спортын газрын барилгыг 124,0 сая төгрөгөөр байгуулж хүлээж авахад бэлэн болсон байна.

ЗУРГАА. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Аймгийн Засаг дарга 2010 онд нийлүүлбэл зохих бүтээгдэхүүнээс тасарсан заалт байхгүй бөгөөд жилийн эцсийн байдлаар **92 хувийн биелэлтэй** дүгнэгдлээ.

Аймгийн нутаг дэвсгэр дэх нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бүлгүүдэд үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг зохион байгуулахдаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт дараах зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна. Хэрэгжилтээс танилцуулбал:

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: Аймгийн хэмжээнд өрхийн чадавхийн судалгааг сум, баг бүрээр 2010 онд шинэчлэн гаргасан 376 өрхийн 1763 иргэн хамрагдсан. Ядуурлаас гарах 376 өрхийн 81 хувь буюу 304 өрхөд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан үйлчилгээг хүргэсэн. Үүнд: 376 өрхийн нийт иргэд хүний хөгжлийн сангаас хувь хүртэж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжид 88 өрхийн 118 иргэн, 149 өрхийн 188 иргэнийг ажилд зуучлаж, 104 өрхийн 145 иргэнийг нийтийг хамарсан ажилд, 58 өрхийн 65 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд, 21 өрхийн 63 иргэн жижиг зээл, 27 өрхийн 87 иргэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд, Засаг даргын тамгын газрын нөөцөөс 313 өрхийн 782 иргэнд тусламж дэмжлэг, 28 өрхийн 53 иргэнийг эрүүл мэндийг дэмжих үйлчилгээнд, 55 өрхийн 191 иргэнийг бусад төсөл хөтөлбөрт, мянганы хөгжлийн сангийн “Хөрөнгийн эрхийн төсөл”-ийн хүрээнд 5 өрхийн газар өмчлөлийн эрхийг салгуулахад нотариатын хөнгөлөлт үзүүлж 28 өрхийн 84 иргэний газар өмчлөх эрхийг баталгаажуулсан байна..

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, ажил олгогч байгууллага, иргэдтэй идэвхтэй хамтран ажилласны үр дүнд нийт 2093 ажлын байрны захиалга хүлээн авч 2028 иргэнийг байнгын болон улирлын түр ажлын байранд зуучлаад байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад байнгын болон улирлын түр ажлын байранд зуучласан иргэдийн тоо 3.5 хувиар өссөн нь зуучлалын үйлчилгээнд чанарын ахиц гарсныг харуулж байна. 2010 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 1040 ажлын байр шинээр бий болсныг www.ejob.mn сайтад бүртгээд байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ХААН банкаар дамжуулан нийт 310.0 сая төгрөгийн зээлийг 210 хүнд олгож 370 ажлын байрыг шинээр бий болгосон байна. Хэлтэс, банк, иргэний хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу зээлийн хүүгийн нөхөн төлбөрийг 35 иргэнд 4032.1 мянган төгрөг олгосон. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 43 байгууллагын 80 иргэн хамрагдаж 40079.1 мянган төгрөгийг зарцууллаа. Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл: Хөдөө аж ахуйн чиглэлээр 320, уул уурхай 464, Боловсруулах үйлдвэр 45, Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж 1, Барилга 33, Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн бараа засварлах үйлчилгээ 45, Зочид буудал зоогийн газар 11, тээвэр агуулахын аж ахуйн холбоо 6, Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа 4, Нийгэм хүнд үзүүлэх бусад үйлчилгээ 29, үл хөдлөх хөрөнгө 2 тус тус байна.

Нийгмийн даатгалын талаар: Аймгийн хэмжээнд Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 6.1 тэрбум төгрөг хуримтлуулахаас **6.9 тэрбум** төгрөгийг төвлөрүүлэн, **758.0 сая** төгрөг буюу **төлөвлөгөөг 112.3** хувиар давуулан биелүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2010 онд **заавал даатгалд 12931**, сайн **дурын даатгалд 1655** хүн тус тус хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад заавал даатгалуулагч **275**, сайн дурын даатгуулагч **277** хүнээр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын тухай багц хуулиар малчид, албан бус секторт ажиллагсад нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулахаар зохицуулжээ. Аймгийн 2009 оны статистикийн мэдээгээр нийгмийн даатгалд хамрагдвал зохих **8501 малчин** байгаагийн **2338 малчин эрүүл мэндийн болон нийгмийн** даатгалд хамрагджээ.

Аймгийн хэмжээнд иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдвал зохих **52000 хүн** амыг хамруулахаас **57023 даатгуулагч** хамрагдаж төлөвлөгөөг **109.6 хувиар** биелүүлээд байна.

2010 онд Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэмж, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаан нь олгож, үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх зорилгоор нийт 10.4 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг сар бүр олгосон.

Аймгийн хэмжээд 2010 онд өндөр насны тэтгэвэр авагч 5738 хүнд 6.9 тэрбум төгрөг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2069 хүнд 1.7 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 980 хүнд 921.8 сая төгрөг, цэргийн тэтгэвэр авагч 399 хүнд 639.1 сая төгрөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэртэй 141 тэтгэвэр авагчда 250.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

ДОЛОО. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Аймгийн Засаг дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх, санхүүжилтийн 2010 оны гэрээний дагуу 5 бүлгийн 24 нэр

төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх үүрэг хүлээснээс хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр **93.0 хувийн** хэрэгжилттэй байна. Хүрсэн үр дүн, хэрэгжилтээс танилцуулбал:

Засгийн Газрын 178 дугаар тогтоолын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь зах зээлийн эрэлт хэрэгцээ болсон үйлдвэрүүдийг дэмжих бодлого барьж ажиллаж ирлээ.

Энэ ажлын хүрээнд хөнгөлттэй зээлд барилгын материалын үйлдвэрт 17 аж ахуйн нэгж иргэнд 175.8 сая төг, өнгөрсөн өвөл цаг агаарын хүндрэлийн улмаас малчид малаа олноор хорогдуулж улмаар эрчимжсэн аж ахуйг түлхүү сонирхож байгаа байдалтай уялдуулж саалийн үнээний эрчимжсэн аж ахуй байгуулахад зориулан 17 аж ахуйн нэгж иргэнд 161.8 сая төгрөг, Орон нутагтаа гутлын үйлдвэрлэл эрхлэх цехүүдийг дэмжих зорилгоор 2 иргэнд 23.2 сая төгрөг, Хадлангийн салааг дэмжиж хэрэгцээт өвсний нөөц бүрдүүлэх зорилгоор 9 иргэнд 83.7, ахуй үйлчилгээний чиглэлээр 12 иргэнд 155.6 сая төгрөгийн зээлийг олгон ажилласан байна.

Ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар хөнгөлттэй зээлд хамрагдахаар 15 иргэн төслөө хүргүүлсэн ба 12 төсөлд 155.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, Хөлөнбуйр, Чойбалсан, Баян – Уул, Цагаан – Овоо сумдад ахуй үйлчилгээний эхлэл тавигдан нийт 28 хүн байнгийн ажлын байраар хангагдан ажиллаж байна. Цаашид ахуй үйлчилгээний нэгдсэн төвтэй болж ажлын байр нэмэгдүүлэх шаардлагатай байна. Аймгийн төв болон сумдад ахуй үйлчилгээний жишиг цогцолбор төв байгуулагдсан байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 2010 оны 37 дугаар тогтоолоор “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг батлуулсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/65 тушаалаар батлагдсан “Хүнсний баталгаат байдал” аянг аймгийн Засаг даргын 2010 оны 276 дугаар захирамжийн дагуу 8-р сарын 1-ээс 30 хоногийн хугацаанд ажлын хэсэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг зохион байгуулжээ.

2010 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Дорнод аймгийн “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Тус төлөвлөгөө нь 3 зорилт, 30 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулагдсан, 2010-2015 он хүртэл хийж гүйцэтгэх ажлыг тусгажээ.

Аймгийн Засаг даргын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 05 тоот Цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай албан даалгаврын 1 дугаар заалтад “Монгол мал” хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг орон нутагтаа сурталчилан, шат шатандаа хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан гаргаж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилийн байдлаар Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэн ажиллахаар заасан байна. Одоогийн байдлаар Дорнод аймгийн 8 сумын Засаг даргын Тамгын газар “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Энэ онд улсын төсвийн 243 сая төгрөгний санхүүжилтээр 14 суманд нийт 18 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, малчдын санаачлагаар 75 энгийн уурхайн худаг гарган ашиглаж байна.

Аймгийн хэмжээнд нийт 2507 уст цэг байгаагийн 314 нь инженерийн хийцтэй, 2193 нь энгийн уурхайн худаг байна. Нийт уст цэгийн 95.5 хувь буюу 2395 уст цэгийг ашиглаж байна. Нийт малчин өрхийн 71.1 хувь буюу 3133 малчин өрх усаар хангагдсан байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн 4486.4 га-д тариалалт хийснээс Үр тариа **4050** га-д, төмс **300.2** га-д, хүнсний ногоо **136.2** га-д тариалсан нь үр тариа тариалах төлөвлөгөө **106.5** хувь, төмс **154.7** хувь, хүнсний ногоо **130.3** хувиар биелсэн байна.

Ургац хураалтаар Улаанбуудай **5074** тн, Гурвалжин будаа **45** тн, төмс **3236** тн, хүнсний ногоо **1520.6** тн-ыг хураан авсан нь өмнөх оныхоос үр тариа **17.6** хувь, төмс **81.5** хувь, хүнсний ногоо **51.5** хувиар нэмэгдэж, аймгийн хүн амын гурилын хэрэгцээний **107.8** хувь, үйлдвэрийн хэрэгцээт буудайн **40.5** хувь, төмсний **94.7** хувь, хүнсний ногооны хэрэгцээг **31.2** хувь хангах боломжтой болов.

2010 онд хөрсийг салхи болон усны эвдрэлээс хамгаалах технологийг нэвтрүүлэх техникийн шинэчлэлээр “Дорнод гурил” ХХК Халхгол сумын “Булгадай” тариа бригадад Джон Дерри фермийн трактор, хийн даралтат үрлэгч, хор шүршигч бүхий иж бүрдэлд, үр тариа хураах комбайн 2 ш, “Үйзэн тал” ХХК Жон Дийр фермийн үр тариа хураа комбайн 2ш, Белорусс сарэкс-1221 трактор 2ш, “Мөнх тал” ХХК Жон Дийр фермийн үр тариа хураах комбайн 1ш шинээр авч нийт **849.6** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна

2010 онд атаршиж өнжөөсөн талбайгаас 5400 га талбайг нэмж ашиглан **8400** га талбайд уринш бэлтгэв. Энэ нь өмнөх оныхоос 6300 га-гаар буюу **4.0** дахин өссөн үзүүлэлт болж байна.

НАЙМ. ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг 2010 оны жилийн эцсийн байдлаар дүгнэхэд **97.0** хувьтай хэрэгжжээ.

Тус салбарын сайдын багцад 4 төрлийн 670 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаас гэрээний дүнгээр 641.031.0 мянган төгрөгөөр бүтээгдээхүүнийг нийлүүлсэн. Сайдын багцын хүрээнд хийгдсэн ажлуудаас дурдвал:

- ❖ Нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн завсарын ажил Хэрлэн сумын 18 байранд хийгдсэн
- ❖ Хотын доторх зам засвар, явган зрчигчийн зам, гэрлэн дохио /Хэрлэн сум/, Равдангийн гудамжны төсгөлөөс нисэх онгоцны буудалын чиглэлийн хатуу хучилттай авто замын угсралтын хийгдэж хүлээлгэн өгсөн

- ❖ Сумын уурын зуухны засвар, шинэчлэл, халаалтын тогоог бүрэн шинэчилсэн
- ❖ Нийтийн орон сууцны цэвэр бохир усны чанар хангамжийг сайжруулах хүрээнд Нийтийн аж ахуйн цэвэр усны шүүлтүүр 4-р цилтерийн цеолит солих ажил хийгдэж техникийн комисс хүлээж авсан.

ЕС. ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Засаг даргын зүгээс гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд хэрэгжүүлж 2010 оны бүтээгдэхүүний нийлүүлэх гэрээг **95.0 хувьтай** хэрэгжүүлсэн байна.

Тус салбарын сайдын багцаас 2 төрлийн эрх шилжиж ирсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр 475 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Эрх шилжиж орон нутагт хийгдсэн Халхгол сумын Ялалт багаас Загасчдын хотхон Буйрын заставын 15кв-ийн 27 км ЦДАШ татах ажил зэрэг ажлууд заасан хугацаанд хийж гүйцэтгэгдсэн байна.

АРВАН . БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Тус салбарын сайдаас аймгийн Засаг даргатай 4 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулж 2010 оны жилийн эцсийн байдлаар **95.0 хувийн** хэрэгжилттэй гарсан байна. Нийлүүлсэн бүтээгдэхүүний хэрэгжилтээс:

Баян-Уул сум дахь сум дундын ойн ангийн “Шар чулуутын булаг” гэдэг газарт 2010 онд 40 га-д БСУТА, 30 га-д 75000 ширхэг нарсны 3 настай тарьцаар ойжуулалт, “Бавж барас” ХХК-ын “Ар битүү, царам” гэдэг газарт 40 га-д БСУТА, 30 га-д 75000 ширхэг нарсны 3 настай тарьцаар ойжуулалт, “Гурван хуст” ХХК-ын 10 га-д ойжуулалт, “Нарс мод” ХХК-ын 4 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт, “Өвөр эрэн” ХХК-ын 10 га-д өөрийн хөрөнгөөр ойжуулалт тус тус хийснийг 6 сард газар дээр нь үзэж, талбайн хэмжээг га-аар нарийвчлан тогтоож, тарьцын тооллого хийж, тарилтын технологи, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгсөн. Мөн 10 дугаар сард ойжуулалтын ажил шалгаж хүлээж авах ажлын хэсэг газар дээр нь үзэж, талбайн хэмжээг га-аар нарийвчлан тогтоож, тарьцын тооллого хийж, актаар хүлээн авав. Нийт 84 га талбайг ойжуулж, 80 га талбайд БСУТАжил хийж, 892.3 мян/ширхэг суулгац тарьж, 35.8 кг үр бэлтгэсэн бөгөөд амьдралт 75.9% тай байна.

БОАЖ-ын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсан булаг шандын эхийг хамгаалах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороо, гүйцэтгэлд хяналт тавих, шалгаж хүлээн авах ажлын хэсгийн комиссыг аймгийн Засаг даргын 2010 оны 146, 147 дугаар захирамжаар байгуулан тендер зарлаж, төсөл сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан Булаг тохижуулах ажлын тендерт “Холбох зам” ХХК, “Чо янзага” ХХК, МБОХХ-ны Дорнод салбар зөвлөл шалгарч тус бүр нь 2 сая төгрөгний төсөвтэй 3 булгийн эхийг

тохижуулах ажлыг гэрээнд заасан хугацаанд зохих зураг төслийн дагуу гүйцэтгэж орон нутгийн иргэдийн төлөөлөл, багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, БОХУБ нарт хүлээлгэн өгсөн байна. Дээрх аж ахуйн нэгжүүд булгийн эхийг хашихдаа төмөр хашааг зохих зураг төслийн дагуу гагнаж чанартай хийж гүйцэтгэсэн.

Аймгийн 6 суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан булаг хаших ажлыг 10, 11 саруудад хийж зохих газруудад хүлээлгэн өгсөн байна.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЖАНЛАВ

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
БАЙГУУЛСАН 2010 ОНЫ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭСЭН ДҮН**

/Дорнод аймаг/

д/д	Салбарын нэр	Бүтээгдэхүүн тоо	Хэрэгжилтийн хувь
1	Монгол улсын Шадар сайд		93.5
2	Хууль зүй дотоод хэргийн сайд		90.0
3	Байгаль орчин аялал жуулчлалын сайд		95.0
4	Батлан хамгаалахын сайд		95.0
5	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд		92.0
6	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд		97.0
7	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд		92.0
8	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд		95.0
9	Эрүүл мэндийн сайд		90.0
10	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд		93.0
	Нийт		93.2

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ